



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/96

Бор-Өндөр сум

**Өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөлтийн
зөрүүг арилгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар “Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай” Тогтоол, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд Бор-Өндөр сумын эзэмшил, өмчлөлийн газарт хийсэн хяналтын хэмжилтээр одоо байгаа нэгж талбарууд хэмжээний зөрүүтэй байсан бөгөөд уг зөрчлийг арилгах зорилгоор хавсралтад дурьдсан 3 иргэнд 1991 мкв газрын хэмжээг залруулж өмчлүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбоотой нэгдүгээр хавсралтад дурдсан өмнөх захирамжийн холбогдох хэсгүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, Газрын Улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ